

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр, Мягмар гараг

	Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
	Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 12
	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	13 - 45
1.	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	14 - 20
2.	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	20 - 23
3.	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	23 - 28
4.	Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./	28 - 45
5.	Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/	45

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 11 дүгээр сарын 05-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 43 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: Т.Аубакир, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Б.Заяабал, Д.Пүрэвдаваа;
Чөлөөтэй: Д.Батбаяр, Х.Булгантуяа, Г.Ганбаатар, З.Мэндсайхан, Г.Тэмүүлэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, Ж.Ганбаатар.*

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, мөн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од, С.Төрмөнх нар байлцав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга, Н.Алтанхуяг нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, мөн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од, С.Төрмөнх нар байлцав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

Улсын Их Хурлын даргаас чиглэл өгсөн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1. Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэлийн гаргасан, 5.2.3.1.“хэрэглээний биотехнологийн лабораторийн тоног төхөөрөмж” гэсэн төсөл, арга хэмжээний “хэрэглээний” гэсний өмнө “Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгийн” гэж нэмж, уг төсөл, арга хэмжээний байршлыг “Улаанбаатар, Баянзүрх” гэж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулгын гаргасан, 15.3.3.1.“Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төвийн тоног төхөөрөмж” гэсэн төсөл, арга хэмжээний байршлыг “Улаанбаатар, Баянгол дүүрэг” гэж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Баясгалан нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 84.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, 13.3.2.“Цаг уурын автомат станц бүсүүдэд” гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Байгаль орчин, цаг уурын салбарын орон нутаг дахь өртөө, харуул, байгаль хамгаалагчийн байр бүсүүдэд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 84.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, 18.1.1.“Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт, улсын төсвийн хөрөнгө бүсүүд” гэсэн төсөл, арга хэмжээний “улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт, улсын төсвийн” гэснийг “улс, аймаг, сумдад хэрэгжүүлэх, шаардагдах улсын төсвийн хөрөнгө” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 84.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, 18.1.2.“Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1 дүгээр үе шат, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт, улсын төсвийн бүсүүд” гэсэн төсөл, арга хэмжээний “үе шат, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт, улсын төсвийн хөрөнгө” гэснийг “үе шатыг аймаг, сумдад хэрэгжүүлэх, шаардагдах улсын төсвийн хөрөнгө” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 2

Бүгд: 13

84.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, мөн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын

албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од, С.Төрмөнх нар байлцав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу Улсын Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ц.Даваасүрэн: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 22.14 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.14.Энэ хуулийн 22.5.22-т заасан төслийн жагсаалтыг Улсын Их Хурал батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ц.Даваасүрэн: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай “38.6” дахь хэсэг нэмэх:

“38.6.Энэ хуулийн 38.4-т хамаарах боловсруулах үйлдвэрийн салбарын жагсаалтыг Улсын Их Хурал батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	3
Бүгд:	13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ц.Даваасүрэн: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 12 дахь хэсгийн 12 дахь заалтыг хасах.

Гурав.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.“Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 12 дахь хэсгийн 12 дахь заалтыг хасах” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	6
Бүгд:	13

53.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 12 дахь хэсгийн 12 дахь заалтын “урамшууллын дүнг” гэсний дараа “бусад хангамжийн талаарх мэдээлэл” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	7
Бүгд:	13

46.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дөрөв. “Засгийн газар үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Ц.Даваасүрэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “2025 онд” гэсний дараа “4.0 их наяд хүртэл төгрөгтэй тэнцэх хэмжээний” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	2
Бүгд:	13

84.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Ц.Даваасүрэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай “1 дэх заалт” нэмэх:

“1.Төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж, цаашид өөрчлөгдөхгүй байх талаар дараах арга

хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэл, шилжилт хөдөлгөөн, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тэдгээрийн гүйцэтгэл, эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэр, техник-эдийн засгийн үндэслэл зэрэг мэдээллийг агуулсан ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийн төрөлжсөн цахим сан бүрдүүлж, улсын бүртгэлийн байгууллага татварын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

2/нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг судалж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт магадлал хийн, аудитын дүгнэлт гаргуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, саналаа 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	8
Бүгд:	13

38.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай “1 дэх заалт” нэмэх:

“1.Төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж, цаашид өөрчлөгдөхгүй байх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэл, шилжилт хөдөлгөөн, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тэдгээрийн гүйцэтгэл, эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэр, техник-эдийн засгийн үндэслэл зэрэг мэдээллийг агуулсан ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийн төрөлжсөн цахим сан бүрдүүлж, улсын

бүртгэлийн байгууллага татварын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

2/нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг судалж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт магадлал хийн, аудитын дүгнэлт гаргуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, саналаа 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	3
Бүгд:	13
76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.	

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хууль зүйн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын дарга З.Баярхүү, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, Усны газрын дарга З.Батбаяр, Цөмийн энергийн комиссын Нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Г.Манлайжав, Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ, Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн газрын дарга Ж.Мөнх-Оргил, “Мон Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, “Мон Атом” ХХК-ийн Геологи, уул уурхайн албаны ахлах инженер А.Алтанхундага нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аж

үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

- Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, П.Мөнхтулга, Б.Түвшин, Ц.Даваасүрэн нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, “Мон Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар хариулж, тайлбар хийв.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт 20¹ зүйлийн 10³ дахь хэсгийн “үнэлгээний ашигт малтмалын нөөцийн төлбөрийг “5 хувиар” гэснийг “9 хувиар” гэж өөрчлөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	5
Бүгд:	13

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

- Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

- Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

- Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

- Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 5 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, санал хураалт явуулж дууслаа.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 1
Бүгд: 13
92.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 38 минут үргэлжилж, 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 21 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
10 цаг 43 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье.

Хуралдааны ирц ирэх ёстой 25 гишүүнээс 13 гишүүн ирж, 52 хувьтай хуралдааны ирц бүрдсэн байна.

Би ирсэн гишүүдийг танилцуулъя.

Ц.Даваасүрэн, Н.Алтанхуяг, Р.Батболд, Ж.Батжаргал, Д.Батлут, Б.Батцэцэг, Ж.Баясгалан, П.Ганзориг, Б.Мөнхсоёл, П.Мөнхтулга, Б.Түвшин, Д.Цогтбаатар, Б.Баттогтох.

Хуралдааны ирц хангалттай болсон учраас хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хороогоор хэлэлцэх асуудлуудыг Та бүхэнд танилцуулъя.

Таван асуудал байна.

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Эцсийн хэлэлцүүлэг.

2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл. Гурав дахь хэлэлцүүлэг.

3.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүд. Эцсийн хэлэлцүүлэг.

4.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Анхны хэлэлцүүлэг.

5.Төсвийн Байнгын хорооны тогтоолын төсөл.

Эдгээр асуудлыг өнөөдөр хэлэлцэхээр төлөвлөсөн байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Эхний асуудалдаа орно.

**Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг/**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэллээ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Б.Жавхлан Сангийн сайд, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Л.Энх-Амгалан Эдийн засгийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Б.Анар Эдийн засгийн хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Г.Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, З.Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Э.Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Л.Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, П.Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Л.Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн

дарга, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр оролцож байгаа юм байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хувилбарыг Та бүхэнд тараасан байгаа.

Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Н.Алтанхуяг гишүүнээр тасаллаа.
П.Мөнхтулга гишүүн асуултаа асууя.

П.Мөнхтулга: Макро эдийн засгийн үзүүлэлт 5.3 хувь болж буурсныг Сангийн сайд зудтай болон малчдын амьжиргаатай холбож тайлбарлаж байсан. Өмнөх бүлгийн хурал дээр. Манай намын.

Тэгээд Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаас асуусан юм. Танайх энэ Дарханы арьс, ширний үйлдвэрээ хэзээ барьж дуусгах юм бэ? Төсөв дээр тавигдсан дүн нь зөвхөн цэвэрлэх байгууламж гээд 2024 оны шилжих дүн яваад байгаа юм.

Тэгээд энэ дээрээ сая нэлээн олон эх үүсвэрүүд суларч байх шиг байна шүү дээ.

Одоо тэр кино үзэх 18 тэрбумыг ард түмэн хүлээн зөвшөөрөхгүй байна. Гэтэл арьс, ширийг бид жалгандаа хаясан хэвээрээ л байна.

Тэгээд нэлээн шахуу төсөв баталж байгаа. Дотоодын нийт бүтээгдэхүүний 37 хувьд төсөв баталчихсан байж байдаг.

Тэгэхээр малчдынхаа амьжиргааг дэмжиж макро эдийн засгийнхаа үзүүлэлтийг нэмэхгүй юм уу? Энэ Дарханы арьс, ширний үйлдвэр дээр төсөв тавиач ээ. Аж ахуйн нэгжүүд нь хөрөнгө оруулалтаа хийх гээд хүлээгээд байгаа юм билээ.

Тэгээд улсаас хөрөнгө оруулах ёстой. Нөгөө дэд бүтцийн хөрөнгө оруулалтуудаа хүлээгээд байгаа юм билээ.

Тэгэхээр энэ оны төсөв дээр одоо энэ эцсийн хэлэлцүүлэг явж байгаа үеэр ард түмэнд таалагдахгүй байгаа тэр 18 тэрбумыг тийш нь малчдын амьжиргаа.

Монгол Улсын хэмжээнд 17 сая мал нядлагдаж байгаа. Ихэнх нь арьс, шир дайвар бүтээгдэхүүнүүд нь хог дээр хаягдаж байна.

Тэгээд мөнгө олдог чиглэл рүүгээ энэ 18 тэрбумаа хийвэл яасан юм бэ гэсэн ийм асуулт болон санал байгаа.

Ц.Даваасүрэн: П.Мөнхтулга гишүүний асуугаад байгаа тэр Соёлын сайдын багцад байгаа 18 тэрбумыг манай Байнгын хорооны ажлын хэсэг хасахаар оруулж ирсэн.

2 удаа санал хураалт явагдаад ингээд хасахаар явж байсан боловч чуулган дээр манай гишүүд босгочихсон.

Тэгээд гурав дахь хэлэлцүүлэг рүү нэгтгээд орж ирж байгаа ийм асуудал байгаа.

Байнгын хорооны ажлын хэсгээс “хасъя” гэж орж ирсэн ийм санал байгаа юм.

Б.Жавхлан сайд саяын асуултад хариулъя. Б.Жавхлан сайдын 5 номерын микрофон.

Б.Жавхлан: Одоо жишээ нь төсвийн хүрээний мэдэгдэл ярьж байгаа. Эдийн засгийн хөгжлийн яамнаас хариулах нь зөв байх.

Тэгээд ч саяын асуудал чинь өөрөө зарчмын зөрүүтэй...

Ц.Даваасүрэн: 18 тэрбумыг одоо хасаж болох уу гээд байгаа байхгүй юу.

Нөгөө Дарханы арьс, шир лүү шилжүүлж болох уу гээд байгаа юм.

Б.Жавхлан: Одоо энэ чинь гуравдугаар хэлэлцүүлэг. Тийм ээ. Шилжиж байгаа үед тэгээд одоо харин яах юм бол доо.

Би тэрийг хэлж мэдэхгүй шүү дээ. Одоо дэгтэй холбоотой асуудал бол Байнгын хорооны ажлын албанаас, Их Хурлаас хариулах нь зөв байх.

Ц.Даваасүрэн: Гуравдугаар хэлэлцүүлэг дээр зөвхөн чиглэл өгсөн саналыг л дахиж хэлэлцэнэ. Тийм ээ. Хариулъя.

Хэн хариулах юм? Тамгын газраас, хуулийнхнаас.

Нөгөө 18 тэрбумын асуудлыг арьс, ширний үйлдвэрийн цогцолбор луу шилжүүлж болох уу гэж байна. Чуулган дээр тэгээд эцэслээд шийдчих шиг болно лээ л дээ.

Байнгын хорооноос, ажлын хэсгээс үүнийг хасъя гэж оруулаад байхад чинь манай гишүүд анхааралгүй хандчихсан байгаа байхгүй юу.

Энэ дээр тайлбар хийгээд Тамгын газар. Одоо энэ өнгөрчихсөн байх аа, аягүй бол. Зөвхөн чиглэл өгсөн асуудлаар л асуудал хөндөгддөг. Б.Баасандорж.

Б.Баасандорж: Төсвийн Байнгын хорооны дарга, гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72.1-д заасны дагуу одоо бол ямар нэгэн санал хураалт өгөх, ялангуяа таны саяын асуудлаар шилжүүлэх асуудал яригдахгүй. Хориотой. Зохицуулаагүй. Боломжгүй гэсэн үг.

Тэгэхээр хоёрдугаар хэлэлцүүлэг дээр энэ бүх асуудлыг ярьж шийдээд, чуулганы нэгдсэн хуралдаан хоёр дахь хэлэлцүүлгийг хийчихсэн. Гурав дахь хэлэлцүүлэгт шилжүүлчихсэн. Гурав дахь хэлэлцүүлэгт хөрөнгө оруулалттай холбоотой найруулгын шинжтэй санал хураалт л явуулах нь зөвшөөрөгдсөн байдаг.

Өөр зарчмын шинжтэй ямар ч санал хураалт байхгүй гэсэн үг. Шинэ санал гарахгүй. Мөн зарчмын зөрүүтэй санал хураалт явахгүй гэсэн үг. Дэгээрээ.

Ц.Даваасүрэн: Тодруулъя. П.Мөнхтулга.

П.Мөнхтулга: Тэгэхээр одоо нөгөө үзвэр үзэх 18 тэрбум дээр чинь нийгмийн нэлээн эсэргүүцэлтэй тулаад байна шүү дээ.

Тэгэхээр Б.Баасандорж даргын хэлж байгаагаар одоо бол ард түмэн яаж ч эсэргүүцээд нэмэргүй гэсэн үг үү?

Ц.Даваасүрэн: Хариулъя. Тамгын газар.

Б.Баасандорж: Гишүүний асуултад хариулъя.

Би “ард түмэн яаж ч эсэргүүцээд нэмэргүй” гэж зүйл хэлээгүй шүү. Гишүүн ээ.

Би танд дэгийн хууль л танилцуулж байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72 дугаар зүйл. “Төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг” гэж байгаа.

72.1 дээр төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгээр Төсвийн Байнгын хороо нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусган, шаардлагатай бол гишүүнээс гаргасан саналын дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүн өөрчлөгдөхгүй, агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, байршилтай холбоотой залруулгыг хийж, төсвийн төслийн хувилбарын танилцуулгын хамт нэгдсэн хуралдаанд оруулна.

Тэгэхээр Байнгын хороон дээр яг дэгийн хуулиараа ийм л зохицуулалттай ажиллах юм.

Тэгэхээр би танд хууль л танилцуулж байгаа юм. Гишүүн ээ. Хууль.

Ц.Даваасүрэн: Манай Байнгын хорооноос хасъя гэж оруулсан санал чуулган дээр уначихаар тэгээд бид гурав дахь хэлэлцүүлэг дээр өөрчлөх эрхгүй болчихож байгаа байхгүй юу. Чуулган тэгээд шийдчихсэн.

Тэгээд гурав дахь хэлэлцүүлэг дээр зөвхөн нөгөө чиглэл өгсөн саналуудыг л дахиж хурааж болно.

Тэгээд ингээд хаагдчихаж байгаа юм. Н.Алтанхуяг гишүүн асуултаа асууя.

Н.Алтанхуяг: Би энэ жилийн төсвийг жаахан аятайхан төсөв болгочихъё гээд гараа өргөж байгаад. Бас баахан хэрүүл уруул хийж байгаад ажлын хэсэгт орж ажилласан юм. Бас горьдлого тээгээд.

Нээрээ улс орноо бодоод, ард түмнээ бодоод, аж ахуйн нэгжээ бодоод жаахан юм хийчихдэг болов уу гэж горьдоод.

Тэгээд та намайг. Биш ээ. Намайг биш. Манай ажлын хэсгийг 3 хуваагаад Б.Түвшин даргаар ахлуулж байгаад урсгал зардал янзал гэсэн.

Ямар их урам зоригтой урсгал зардал хусаж орж ирлээ.

Тэгээд л энэ тоглоомын юм болж байна, Их Хурал бол. Тэгээд л баахан хүн ажиллуулаад л юм хийлгэхээд одоо юу

гэж хэлж байна вэ гэхээр хуулиа барина, төддүгээр хэлэлцүүлэг дээр тэгсэн.

Энэ бол юу вэ гэхээр улс төрийн хүсэл зориг Монгол Ардын намд алга.

Би 4 үзүүлэлт хэлье.

Нэгдүгээрт, улсын **“төсвийн зарлага”**-ыг бууруулаач.

Өчигдөр 4 гишүүн хэвлэлийн бага хурал хийгээд байна лээ. Маш зөв зүйтэй. Би 5 дахь гишүүн нь мөн шүү.

Энэ маш аюултай. Төсвийн зарлагыг та нар 5 их наядаар нэмж аваад дотоодын нийт бүтээгдэхүүний 38 хувьд хүргэж байгаа гэдэг бол Монгол Улсыг сүйрүүлж байгаа алхам.

Үүнийг энэ Б.Жавхлан мэдэхийн дээдээр мэдэж байгаа. Тэгэхдээ хүсэхгүй байна. Үүнийг өөрчлөхийг хүсэхгүй байна.

Хоёр дахь нь, **“төсвийн орлого”** 2 жилийн дотор 2 дахин их нэмэгдэж байгаа.

Энэ бол аж ахуйн нэгжийг л алж байгаа гэсэн үг.

Тэгэхээр үүнийг өөрчлөх сонирхол байхгүй байна.

Гурав дахь нь, **“төсвийн тэнцэл”** асар их алдагдалтай.

Дөрөв дэх нь, **“өр”**.

Энэ төсвийн тэнцлийн алдагдлыг дагаад гадаадаас зээл авна. Өр шир нэмнэ. Монголчууд.

Ийм юмны эсрэг энэ олон гишүүд үүнийг өөрчилье гэж яриад байхад үүнийг огт тоохгүйгээр салаавч гаргаад, хууль яриад ингэж явдаг парламент гэж байхгүй. Парламент байхгүй байна. Энэ бол нэг нам юм уу, одоо тэр намд дагаар орсон хэдэн хүн л үүнийг хийж байна.

Одоо ард түмэнд үнэнийг нь хэлэх хэрэгтэй байна. Бид төсвийг ингэж баталж болохгүй.

Б.Жавхлан одоо чи эндээс гараад Ерөнхий сайдтайгаа уулзаад төсвөө татаж ав.

Та нар бид нарын хэрэгт оруулаад. Бид яахаараа Засгийн газартайгаа хэрэлдээд сууж байдаг юм.

Бид биш Монгол Улсын Засгийн газар ард түмнийхээ төлөө, аж ахуйн нэгжийнхээ төлөө, монголчуудынхаа сайн сайхан амьдралын төлөө өөрөө сэтгэл гаргаж, өөрөө юмаа засаж орж ирмээр байна.

Ц.Даваасүрэн: Байнгын хорооны ажлын хэсгийг би сайн ажилласан гэж бодож байгаа.

Манай урсгал зардлыг Б.Түвшин гишүүн ахалсан. Б.Түвшин гишүүн нийтдээ бараг 32 тэрбум төгрөгийн зардлыг хасъя гэдэг санал эцэслэж гаргасан. Тэр дотор одоо яригдаад байгаа 18 тэрбум байсан.

Тэгээд 18 тэрбумыг нь чуулган дээр гишүүд олонхын саналаараа босгочхож байгаа байхгүй юу.

Ажлын хэсэг, Байнгын хороо “хасъя” гэж оруулсан.

“Өр”-ийн хувьд “дүн байхгүй байна” гэдэг асуудал яригдсан.

Байнгын хороо “4 их наядаас хэтрүүлэхгүй”, “хүртэл” гэж тавьж өгсөн.

Тийм учраас “хязгааргүй байна”, “хязгааргүй өр авах гэж байна” гэдгийг харин Байнгын хороо хязгаарласан байгаа.

Б.Жавхлан сайд хариулчихъя. Н.Алтанхуяг гишүүний асуулт.

Б.Жавхлан: Н.Алтанхуяг гишүүний санал дээр би дахиад санал хэлэх л болж байх шиг байна даа. Тийм ээ.

Манай Н.Алтанхуяг гишүүн Байнгын хорооны ажлын хэсэг дээр нэр нь байсан. Харин нэг л удаа хуралдаа харагдана лээ. Та нэг л удаа хурал дээрээ харагдсан шүү. Та огт суугаагүй. Ажлын хэсгийн хуралд суугаагүй.

Би танд 4 үзүүлэлт танд сануулъя.

Монгол Улс, Засгийн газар таны Ерөнхий сайд байх үеэс хойших бүх өрийг чинь төлж байгаа шүү. Нэгдүгээрт.

▷ Таны тавьсан өрийг одоо үед төлж байгаа.

▷ Таны буулгасан зээлжих зэрэглэлийг одоо арайхийж нэг тогтоож авч байгаа.

▷ Таны царцаасан бүх хөрөнгө оруулалт, бүх бүтээн байгуулалтыг чинь одоо энэ үед нэг гүйцээж дуусгаж байгаа.

Нэг иймэрхүү үзүүлэлтүүдтэй байгаа шүү. Н.Алтанхуяг гишүүн ээ.

Та өөрөө үүнийгээ сайн хараарай.

Ц.Даваасүрэн: Н.Алтанхуяг
гишүүн нэмэлт 1 минут.

Н.Алтанхуяг: Б.Жавхлан
Монголын ард түмний өмнө чи
хариуцлага хүлээх цаг ирнэ.

Танай Засгийн газар ч гэсэн тэр
хариуцлага хүлээх цаг ирнэ.

Өнөөдөр та нар олонхдоо
дулдуйдаж, кнопдоо дулдуйдаж, хүч
тамир, мөнгө бярдээ дулдуйдаж их
дээрэлхэж байна.

Та нар бид нарыг дээрэлхээгүй,
ард түмнийг дээрэлхэж байна. Бид нар
ард түмний төлөөлөгч.

Тэр Түвшин. Ямар түвшин билээ?
Д.Энхтүвшин, Ж.Баярмаа. Нэг нь хэн
байсан юм? Г.Тэмүүлэн.

Бүгд л зөв юм ярьж байна шүү дээ.

Их Хурлын гишүүд зөв юм ярьж
байхад яагаад тэрийг сонсоод засаж
болдоггүй. Чи яахаараа 10 жилийн өмнө,
20 жилийн өмнөхөн өнгөрсөн баларсан
юм ярьж сууж байдаг юм.

Та нар 8 жил юу хийсэн юм.
Ардчилсан нам ямар хөтөлбөр гаргасан
юм.

Алдагдсан 8 жилийн алдааг засъя
гэсэн. Хаана байгаа юм. Засаж байгаа нь.

Ардын нам төсвийн зарлагыг 25
хувь бууруулна. Үгүй ээ, чи өөрөө тэрийг
хийж орж ирээ биз дээ. Ард түмэн та
нарыг тэгж.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Одоо больцгооё.
Одоо тэгвэл дахиад 1 минут. Тэгээд л
болчхож байгаа юм.

Би яг дэгээр л явахгүй болохгүй
шүү дээ. Дахиад 1 минут.

Н.Алтанхуяг: Яасан их дэг
барьдаг юм та нар.

Та нар дэг барих ёстой юм уу?
Монголын ард түмний ахуй амьжиргааг
дээшлүүлж, аж ахуйн нэгжүүдийгээ
босгож, хөл дээр нь зогсоож, улс орноо
хөгжүүлэх ёстой юм уу? Эсвэл дэг барьж
байна гээд хүмүүсийн амыг хаагаад
суулгаж байх ёстой юм уу?

Би энд чинь олон удаа сууж байна.

Ийм олон гишүүд эсэргүүцээд
байхад хүчиндэж байгаад. Одоо бол
эцсийн хэлэлцүүлэг. Эцсийн үг ч
байхгүй. Ийм юм байдаггүй юм.

Ц.Даваасүрэн дарга уг нь манай
талд байсан юм. Одоо бас дайсны талд
орчхож.

Уг нь яг энэ төсвийн
хэлэлцүүлгийг эхлэхэд манай талд
эхэлсэн шүү дээ. Нээрээ хэдүүлээ төсвөө
гоё болгоё, засъя, янзалъя. Ард түмэн,
ахуй амьжиргаа, аж ахуйн нэгжээ одоо
гоё болгоё гэсэн. Одоо байхгүй.

Одоо ийм тоглоомын юмаа
болимоор байна.

Би сая ирц гүйцээх үү, байх уу гэж
байгаад орж ирсэн юм.

Би та нарыг өөр юм ярих байх гэж
бодож орж ирсэн юм.

Тэр 4 гишүүний саналын дагуу би Засгийн газар, Б.Жавхлан ороод ирсэн учраас юм хумаа татаж аваад. Юманд наанатай, цаанатай. Бас зарим нэг юмыг нь хасчихъя.

Тэр бусдаар.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Минут дууслаа.

Би ямар ч гэлээ гэсэн Байнгын хорооны зүгээс гишүүдийн гаргасан бүх ажил дээр хасъя гэсэн саналыг оруулсан шүү. 18 тэрбумыг Байнгын хороо хасъя гээд л оруулсан. Чуулган дээр л болсон.

Тийм учраас чуулганы тэр олон гишүүдийг би зохицуулж чадахгүй шүү дээ. Их Хурлын дарга биш юм чинь.

Тийм учраас тэр бол одоо надад хамаарахгүй асуудал байна. Манай Байнгын хороо хасъя гээд л оруулсан.

Гишүүд асуулт асууж, хариулт авлаа. /алх цохив/

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин танилцуулчих уу? П.Мөнхтулга танилцуулчих уу? Чуулган дээр. Хэн танилцуулах вэ? Саналтай хүн байна уу? П.Ганзориг танилцуулъя.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Хоёр дахь асуудалд орёе.

**Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай,
Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн,
гурав дахь хэлэлцүүлэг/**

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 3 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн өмнөх хэвээр байна.

Нэгдсэн хуралдаанаар хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан

саналыг төсвийн төсөлд нэмж тусгасан эцсийн хувилбарыг Та бүхэнд тараасан.

Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72.1-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчлөхгүй, агуулга, зарчмыг

алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, байршилтай холбоотой залруулга хийх саналтай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Ингээд Их Хурлын даргаас чиглэл өгсөн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулна.

Биш ээ биш. Та нар санал гаргах уу гэсэн чинь та нар гаргаагүй. Нөгөө чиглэл өгсөн саналуудыг одоо хураалгана.

Их Хурлын даргаас чиглэл өгсөн нэг дэх санал.

Нэг. 5.2.3.1.хэрэглээний био технологийн лабораторийн тоног төхөөрөмж гэсэн төсөл, арга хэмжээний “хэрэглээний” гэсний өмнө “Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгийн” гэж нэмж уг төсөл, арга хэмжээний байршлыг Улаанбаатар, Баянзүрх гэж тусгах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл. Тараасан байх. Та нарт.

Тардаггүй юм гэнэ ээ. Нөгөө чиглэл өгсөн санал учраас. Тийм. Чиглэл өгөөд нөгөө нэр томьёо, байршил өөрчлөх саналууд юм байна.

Д.Рэгдэл гишүүний гаргасан энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

5.2.3.1-ийн хэрэглээний биотехнологийн лабораторийн тоног төхөөрөмж гэсэн төсөл, арга хэмжээний “хэрэглээний” гэсний өмнө “Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгийн” гэж нэмж уг төсөл, арга хэмжээний байршлыг Улаанбаатар, Баянзүрх гэж тусгах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл. Энэ өмнө нь хураагдсан санал. Хураагдахдаа нөгөө био технологийн лабораторийн тоног төхөөрөмж гээд хураагдчихсан байхгүй юу. Тэрийгээ тодруулж байгаа юм байна. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

13 гишүүн санал хураалтад оролцож, 9 гишүүн дэмжиж, 69.2 хувиар байршил өөрчлөгдсөн энэ санал дэмжигдсэн байна.

Хоёр дахь санал. 15.3.3.1.Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төвийн тоног төхөөрөмж гэсэн төсөл, арга хэмжээний байршлыг Улаанбаатар, Баянгол дүүрэг гэж тусгах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга.

П.Мөнхтулга гишүүний гаргасан энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 69.2 хувиар санал дэмжигдсэн байна.

Ж.Батжаргал гишүүн, Ж.Баясгалан гишүүн хоёрын. Өөр байна уу? Дэмжсэн саналыг протоколд тэмдэглэе.

Дараагийн санал хураалт.

Гурав. 13.3.2.цаг уурын автомат станц бүсүүдэд гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Байгаль орчин, цаг уурын салбарын орон нутаг дахь өртөө, харуул, байгаль хамгаалагчийн байр бүсүүдэд” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа.

Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

13 гишүүн санал хураалтад оролцож, 10 гишүүн дэмжиж 76.9 хувиар уг санал дэмжигдлээ.

Д.Батлут гишүүн дэмжсэн байна. Протоколд тэмдэглэе.

Дөрөв дэх санал. 18.1.1.“Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт, улсын төсвийн хөрөнгө бүсүүд гэсэн төсөл, арга хэмжээний улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт, улсын төсвийн” гэснийг “улс, аймаг, сумдад хэрэгжүүлэх, шаардагдах улсын төсвийн хөрөнгө” гэж өөрчлөх.

Санал гаргасан. Энэ санал байна шүү дээ, Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 2-т “нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно” гэсэн Үндсэн хуулийн заалттай зөрчилдөж байгаа. Цэцэд очих магадлалтай байгаа учраас иргэдийн Хурал руу заавал хамтар гэж чиглэл өгч болохгүй юм билээ л дээ.

Тийм учраас үүнийгээ миний гаргасан санал гээд хураалгачихъя. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 13 гишүүн орсон, 10 гишүүн дэмжиж, 76.9 хувиар дэмжигдсэн байна.

Ж.Батжаргал гишүүн нэмж протоколд дэмжсэнээр тэмдэглүүлж байна.

Тав дахь санал. 18.1.2.Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1 дүгээр үе шат, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт, улсын төсвийн бүсүүд гэсэн төсөл, арга хэмжээний үе шат, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт, улсын төсвийн хөрөнгө” гэснийг “үе шатыг аймаг, сумдад хэрэгжүүлэх, шаардагдах улсын төсвийн хөрөнгө” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Ж.Баясгалан гишүүний микрофоныг өгье.

Ж.Баясгалан: Гишүүдийн дунд үл ойлголцол гэх юм уу, бас мэдэхгүй юм яваад байгаа. Энэ гишүүдийн туслахын төсөв хэд байгаа юм бэ? 4 хүнээр байгаа юм уу? Эсвэл Сангийн яаман дээр яг хэдээр тусгагдсан байгаа юм? 2024 он, 2025 он дээрээ. Үүнийг яг тодорхой хэлээд өгөөч ээ. 2 юм уу, 3 юм уу, 4 юм уу? Бүх гишүүд шүү дээ. Эсвэл жагсаалт тойрог гэдгээрээ өөр байгаа юм. уу?

Ц.Даваасүрэн: Б.Жавхлан сайдын микрофоныг. 5. Товчхон л ярьчихгүй юу.

Энэ нөгөө гишүүний яг санал хураалтаас өөр юм байна.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын Тамгын газар дээр яг орон тоогоор нь ирүүлсэн төсвийг баталсан байгаа.

Их Хурлын дарга 1, Их Хурлын дэд дарга 2. 120. Тийм. Их Хурлын дарга, 2 дэд даргыг оруулаад шүү.

Тэгээд нэмэх нь Улсын Их Хурлын гишүүн 123, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх 126, Улсын Их Хурлын гишүүний туслах 126, Улсын Их Хурлын гишүүний бие төлөөлөгч туслах нийлээд 252, бүгд нийлээд 630 гэсэн орон тоотойгоор төсвийг хянаж төсөвлөж оруулсан байгаа.

Ц.Даваасүрэн: 5 номерын микрофон.

Б.Жавхлан: Саяын миний дурдсан зүйл бол 2025 оны төсөв шүү. Одоо бид 2005 оны төсөв ярьж байгаа. 2024 оны төсөв одоо яг хэрэгжиж байгаа. 2024 оны төсөв, 2025 оны төсөв яг энэ Улсын Их Хурлын саяын миний дурдсан орон тоонууд хэвээрээ байгаа.

Ц.Даваасүрэн: Нөгөө аймгуудад төлөөлөгч нар ажиллах ёстой учраас тэр хэвээрээ байгаа юм байна. Тийм тийм. Зөв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооноос гаргах танилцуулгыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд би өөрөө танилцуулчихъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Дараагийн асуудалдаа орёе.

Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн өмнөх хэвээрээ байгаа. Өөрчлөлт ороогүй.

Нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн

төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 5 хууль, Монгол Улсын Их Хурлын 3 тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийх үед олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналыг хууль, тогтоолын төслүүдэд нэмж тусган, төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хувилбарыг Та бүхэнд тараасан.

Та бүхэнд тараасан эцсийн хувилбартай холбогдуулаад асуух

асуулттай гишүүн байна уу? Алга байна.
/алх цохив/

Б.Мөнхсоёл гишүүн энэ дээр юм уу? Төсөв дээр төсөв чинь өнгөрчихлөө шүү дээ. Энэ чинь дагасан хууль шүү дээ. Төсөв өнгөрчихсөн.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсөн 5 зарчмын зөрүүтэй санал байгаа. Энэ саналаар санал хураалт явуулж эхэлье.
/алх цохив/

Гүйцээн боловсруулах чиглэл өгсөн санал. Энэ дээр бас хэдүүлээ санал солилцох юмнууд, тайлбар хийх юм байгаа шүү.

Нэг.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 22.14 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.14.Энэ хуулийн 22.5.22-т заасан төслийн жагсаалтыг Улсын Их Хурал батална.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ дээр ямар асуудал үүсээд байсан гэхээр “Засгийн газрын өргөн мэдүүлсэнээр” гэж оруулъя гээд тэгээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ чинь бусад хууль санаачлагчийнхаа эрхэд халдсан ийм хэрэг болчихож байгаа учраас

өөрчлөхгүйгээр өмнө нь ажлын хэсгээс гаргасан саналаар нь явуулъя гэж байгаа юм. Одоо Ерөнхийлөгч гаргаж болно. Тийм ээ.

Тийм учраас ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 69.2 хувьд уг санал дэмжигдсэн байна.

Ж.Батжаргал гишүүнийг дэмжсэнээр авъя. Протоколд.

Хоёр.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

Энэ дээр ийм асуудал байгаа юм. Нөгөө боловсруулах үйлдвэрийг Б.Энхбаяр гишүүн болохоор “төслүүдийг жагсаалт” гээд байгаа шүү дээ. Бидний оруулсан санал бол “салбарын жагсаалт” гэж байгаа.

Тэгэхээр одоо Та бүхэнд танилцуулж байгаа хувилбар бол салбараараа. Энэ дээр саналтай гишүүн байна уу? Би уншлаа.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 38.6 дахь хэсэг нэмэх:

“38.6.энэ хуулийн 38.4-д хамаарах боловсруулах үйлдвэрийн салбарын жагсаалтыг Улсын Их Хурал батална.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, ажлын

хэсгийн санал 76.9 хувиар дэмжигдсэн байна.

Гурав. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1. “Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 12 дахь хэсгийн 12 дахь заалтыг хасах”.

Санал гаргасан Ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

13 гишүүн санал хураалтад оролцож, 7 гишүүн дэмжиж, 53.9 хувиар дэмжигдсэн байна.

Д.Батлут гишүүнийг дэмжсэнээр авъя. Уг санал дэмжигдлээ.

Г.Лувсанжамц гишүүний гаргасан, чиглэл авсан санал.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 12 дахь хэсгийн 12 дахь заалтын “урамшууллын дүнг” гэсний дараа “бусад хангамжийн талаарх мэдээлэл” гэж нэмэх

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц. Үгүй яах вэ, тэр нь нөгөө 12 нь юугаараа үлдэж байна гэсэн үг шүү дээ. Нөгөө орж ирснээрээ. Бид хасъя гэж байсан байхгүй юу.

Энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Заавал гишүүн санал гаргасан учраас хураалгах ёстой юм гэнэ.

13 гишүүн санал хураалтад оролцож, 6 гишүүн дэмжиж, 46.2 хувиар энэ санал дэмжигдсэнгүй.

Дөрөв. “Засгийн газар үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар.

Энэ дээр ямар чиглэл ирсэн гэхээр бид 4 их наяд хүртэл гээд Засгийн газраас нөгөө нэг тоогүй орж ирээд, тоотой болгосон шүү дээ. Хэрвээ энэ санал дэмжигдэхгүй болчих юм бол нөгөө тоогүйгээрээ үлдэнэ.

Тэгэхээр бид үүнийгээ дэмжээд явсан нь дээр байх.

1. Төслийн 1 дэх заалтын. Г.Тэмүүлэн гишүүн энэ дээр нөгөө 2.5 гээд байсан. Тэгэхдээ Г.Тэмүүлэн гишүүний санал чинь нөгөө санал хураалтад орохгүй юм билээ.

Одоо бол ажлын хэсгийн саналыг хураалгах ёстой юм.

Төслийн 1 дэх заалтын “2025 онд” гэсний дараа “4 их наяд хүртэл төгрөгтэй тэнцэх хэмжээний” гэж нэмэх санал гаргасан. Ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая. /алх цохив/

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, уг санал нь 84.6 хувиар дэмжигдсэн байна.

Тав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар чиглэл өгсөн.

Энэ тогтоол дээр нэг заалт нэмэгдэж байгаа. Би та нартай уншаад танилцуулчихъя.

Соёлын сайдын төсвийн багцад тусгагдсан Монгол Улсын 16-аас 18 насны иргэнд Соёлын бүтээгдэхүүн,

үйлчилгээ худалдан авах эрхийн бичигт зарцуулах хөрөнгийг. Бүгдийг нь унших юм уу? Яг өөрчлөлт орсон юм уу, ороогүй юм байгаа биз дээ.

Ж.Батжаргал гишүүний санал юм байна шүү дээ. Тийм байна.

Энэ төсөлд чинь нөгөө 3 дахь заалт улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга, байгууламжийн төсөвт магадлал хийн аудитын дүгнэлт гаргуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж саналаа 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах гэж өөрчлөлт орж байгаа юм байна шүү. Чиглэл аваад.

Бүгдийг нь уншиж яадаг юм. Бусад нь өөрчлөгдөөгүй шүү дээ. Хэвээрээ.

Бусад нь хэвээрээ шүү. Өмнөх 1, 2 дугаар заалтууд нь хэвээрээ.

4 дэх заалт нэмэгдэж байгаа нь, тэр нөгөө 18 тэрбум төгрөгийн ваучерын асуудал байна шүү дээ. Нөгөө хүүхдүүд гээд байгаа. Тэрийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 8.4-д заасан журмын дагуу зарцуулж тайланг тухай бүр ил тод, нээлттэй тайлагнаж, үр нөлөөг үнэлэх гэдэг ийм чиглэл оруулж байгаа юм байна.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төслийн талаар гаргасан ажлын хэсгийн саналыг дэмжжэ гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Б.Жавхлан сайд 5. Тэр чинь нөгөө хугацаатай холбогдолтой.

Б.Жавхлан: Тийм. Энэ хугацаа тавиад ийм үүрэг авч болно. Болно. Асуудалгүй.

Гол нь зүгээр нэг ийм зарчим л байгаа юм. даа. Энэ төсөвт өртөг нэмдэг ийм нэг сонин ийм технологи, хонгил үүсчих вий дээ. Их Хурал дээр л ингээд нэмдэг болдог юм байна гээд.

Энэ Их Хурлын гишүүдийг ч тэр, Их Хурлыг ч гэсэн эвгүй байдалд оруулах вий.

Ер нь энэ заалтаасаа өмнө энэ төсөвт өртөг нэмэгдээд байгаа энэ эрсдэл хаанаас яаж үүсэж байна вэ, энэ төсөвт өртгийг хаана, ямар экспертүүд үүнийг нэмдэг юм.

Цаашдаа төсөвт өртөг нэмэгдэхгүй байх. Анх орж ирж байгаа төсөл нь батлагдаад, тэрнээс хойш эрсдэл гарахгүй байх энэ зарчмаа хатуу сахих гэдэг. Тэрийгээ зааж өгч байж дараа нь үүнийгээ ярихгүй бол энэ нэг л ийм буруу жишиг, буруу хонгил үүснэ дээ.

Ц.Даваасүрэн: Их Хурал үүнийг шууд нэмээд ороод ир гээд байгаа юм биш шүү дээ.

Та нарыг үүнийгээ судалж үз ээ гэж. Чи чинь өөрөө бичиг явуулсан юм билээ шүү дээ. Над руу. Байнгын хороо руу бичиг явуулчихсан юм билээ шүү дээ.

Тийм учраас Байнгын хороо шууд үүнийг чинь тэр 160 тэрбумыг чинь оруулах боломжгүй байгаа учраас үүнийгээ тодруул гэж байхгүй юу даа.

Үүнийг чинь одоо тэгээд бүхэлд нь оруулах юм уу, бүхэлд нь хасах юм уу, хэсэгчилж оруулах юм уу. Тэрийгээ

шийдэж ир гэж байгаа болохоос Их Хурал одоо үүнийг бид шууд нэм ээ гэсэн чиглэл өгөөгүй байхгүй юу.

Магадлал хийн, аудитын дүгнэлт гаргуулах арга хэмжээ ав гэж байгаа байхгүй юу. Үгүй аль аль нь юм байна. Цалин ч төсөвт өртөг нэмэгдүүлж байгаа, барилгын материал төсөвт өртөг нэмэгдүүлж байгаа байх.

Энэ дээр болохоор ингэсэн байна. Төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн гэсэн байна. Энд нь магадлал хий л гэж байна.

Тэгээд аудитын дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуул гэж.

Тийм учраас бид шууд төсөв нэм гээгүй.

Хүчингүй болгох санал хураалт явуулаад тэгээд. Б.Түвшин гишүүний микрофоныг өгье.

Б.Түвшин: Саяын санал дээр зарчмын зөрүүтэй хэд хэдэн заалтууд орсон учраас зарим саналуудыг нь хасаад, заримыг нь дэмжих ийм бодолтой байгаа учраас дахиж санал хураалтыг зөв томьёолж оруулж ирж өгнө үү гэж хүсэж байна.

Ц.Даваасүрэн: Саяын хураасан саналыг хүчингүй болгох санал хураалтыг Б.Түвшин гишүүний горимын саналын дагуу явуулъя. /алх цохив/

13 гишүүн санал хураалтад оролцож, 9 гишүүн горимын саналыг дэмжсэн байна. 69.2 хувиар горимын санал дэмжигдлээ.

Ингээд дахин санал хураалт явуулъя.

Тэр ажлын хэсгээс тэр 4 дэх санал юм байна шүү. 4 дэх тэр Соёлын сайдын багцын гэдгийг татчихъя. Энэ саналыг татаад.

Одоо ийм санал хураалгана. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1.Төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж, цаашид өөрчлөгдөхгүй байх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-д даалгасугай.

1.Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэл, шилжилт хөдөлгөөн, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тэдгээрийн гүйцэтгэл, эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэр, техник, эдийн засгийн үндэслэл зэрэг мэдээллийг агуулсан ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийг төрөлжсөн цахим сан бүрдүүлж, улсын бүртгэлийн байгууллага, татварын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авах.

2.Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг судалж Их Хуралд өргөн мэдүүлэх.

3.Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга, байгууламжийн төсөвт магадлал хийн аудитын дүгнэлт гаргуулах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулж саналаа 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

13 гишүүн санал хураалтад оролцож, 10 гишүүн дэмжиж, 76.9 хувиар уг санал дэмжигдсэн байна.

Санал хураалт явуулж дууслаа.
/алх цохив/

Хууль тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан танилцуулчих уу. Ж.Баясгалан гишүүн.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Дөрөв дэх асуудалдаа орёе.

**Дөрөв.Цөмийн энергийн тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн
Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг,
санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын
байнгын хороонд хүргүүлнэ./**

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулна.

Н.Учрал Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Н.Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн

хэлтсийн дарга, Т.Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хууль зүйн хэлтсийн дарга, Г.Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, З.Баярхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Б.Мөнхтогтох Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны салбарын хяналтын газрын дарга, З.Батбаяр Усны газрын дарга, Г.Манлайжав Цөмийн энергийн комиссын Нарийн бичгийн

дарга бөгөөд ажлын албаны дарга, Э.Нямдаваа Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга, Б.Гэрлээ “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер, Ж.Мөнх-Оргил Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн газрын дарга, Д.Далайжаргал “Мон Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал, А.Алтанхундага “Мон Атом” ХХК-ийн Геологи, уул уурхайн албаны ахлах инженер.

Ийм улсууд оролцож байгаа юм. байна.

Монгол Улсын Их Хурлын хуралдааны чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх ёстой.

Цөмийн энергийн тухай хуульд заасан нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 5 зүйлтэй бөгөөд хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье.

Цөмийн энергийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн [1 дүгээр зүйл](#)-тэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? 1 дүгээр зүйл.

Асуух асуулттай гишүүн байна уу? Б.Түвшин гишүүнээр тасалъя. Ж.Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа.

Тэгэхээр Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль өргөн баригдаад ороод ирчхээд байгаа юм.

Энергийн энэ хуульд оруулж байгаа өөрчлөлтүүдийг хараад байхаар

зэрэг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөрөө төрийн өнөө үнэ төлбөргүй эзэмших хувиа одоо дүйцүүлж тооцож болохоор ийм эрх зүйн зохицуулалт орж ирээд байна л даа.

Тийм учраас АМНАТ нь өөрөө 5, тусгай АМНАТ гэж байхаар, өсөн нэмэгдэх АМНАТ гэж байхаар яригдаад байгаа. Нийт дүнгээрээ 19 байхаар харагдаж байгаа юм шиг байгаа юм. Би тэгж ойлгоод байгаа.

Тэгэхээр төрийн эзэмшлийн хувиа тодорхой АМНАТ-аар орлуулж болох эсэхийг нь би 14 орчим хувь байх юм байна гэсэн тооцоолол харагдаад байгаа байхгүй юу. Энэнээс харахаар зэрэг.

Тэгэхээр энэ чинь хувийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хайгуултай. Тэгээд нөөц нь баталгаажчихсан ордын 34 хүртэл хувийг үнэ төлбөргүй эзэмших зохицуулалт бидний өмнө баталсан хуулиудад байгаа.

Тэгэхээр тэр 14 хувь өөрөө тэрэнтэй дүйх хэмжээний тооцооллийг ер нь ямархуу байдлаар хийчих вэ гэдэг асуудал байгаа юм. Үүнийг ер нь тооцооллынх нь хувьд яаж авч үзсэн ийм зүйл байна вэ гэж. Нэг ийм зүйл харагдаад байгаа гэж.

Хоёрдугаарт, ордын онцлог ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшнээс нь хамаарч тэр тусгай АМНАТ-ын тухай асуудал яригдах юм байна гэсэн ийм тооцоолол гарч ирээд байгаа юм.

Тэгэхээр ордын онцлог гэдэгт бид юуг ойлгож байгаа вэ? Зах зээлийн үнэ тодорхой юм байж.

Тэгэхээр ордын онцлог гэдэгт бид юуг тооцож авч үзэж оруулж ирээд

байгаа вэ гэдэг нэг ийм зүйл байгаа юм. Үүнийг нэг тодруулах ёстой юм болов уу гэж ойлгоод байгаа.

Цаад ер нь уг Цөмийн энергийн тухай хуульдаа бид яг нарийндаа энэ цацраг идэвхт ашигт малтмалыг эрэн хайх, олборлохтой холбоотой харилцаа нь байгаа юм уу гэж хараад байгаа. Үүнийг аль болохоор улс үндэстнийхээ эрх ашигт нийцүүлж, эцсийн бүтээгдэхүүн рүү чиглэх эсэх дээрх энэ харилцааг нэгэнтээ нэмэлт хийж байгаа бол энэ рүү оруулж ирэх бололцоо байгаагүй юу гэдэг асуудал байгаа юм.

Дэлхий нийтээрээ хамгийн хямд, бас тэгээд ногоон байж болох эрчим хүчний эх үүсвэрийг энэ цацраг идэвх дээр тулгуурласан станцын тухай асуудал байна гэж яриад байдаг.

Гэтэл бид хэд жаал байгаа.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 1 минутаа авах юм уу? Ж.Батжаргал гишүүний 1 минутыг өгье.

Ж.Батжаргал: Хагас боловсруулж гадагш нь гаргах эрх зүйн зохицуулалтыг нь хийчхээд байдаг.

Тэгэхээр жижиг оврын гэдэг юм уу, дунд оврын гэдэг юм уу...

Ц.Даваасүрэн: Н.Учрал сайдыг дуудъя.

Ж.Батжаргал: ...станцын асуудлыг ер нь энэ хуулийн үзэл санаанд нэмэлтээр оруулж ирэх бололцоо байгаагүй гэдэг ийм санаа л байгаад байна л даа, надад бол. Энэ дээр ер нь ямар ойлголт, ямар одоо асуудал байна вэ

гэж нэг ийм хэдэн зүйл дээр тодорхой хариулт авмаар байна.

Ц.Даваасүрэн: Энэ тэгээд дэд дарга нь Д.Цолмон байна уу?

Тэгвэл Д.Цолмон хариулж байх уу. Н.Учрал сайдыг дуудахгүй бол. 5 номерын микрофон өгье.

Д.Цолмон: Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Д.Цолмон.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд ерөнхийдөө яг энэ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой зохицуулалт бүхэлдээ орж ирсэн.

Цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглахтай холбоотой харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулахгүй гэдэг энэ үндсэн зарчмын хүрээнд яг Ашигт малтмалын хуульд заасан ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон төлбөртэй холбоотой зохицуулалтыг нэгэн адил Цөмийн энергийн тухай хуульд оруулж өгсөн гэсэн үг.

Тэгэхээр энэ АМНАТ бол ерөнхийдөө 3 төрлийн АМНАТ-тай байгаа.

→ Суурь АМНАТ буюу борлуулалтын үнэлгээний 5 хувиар тооцохоор орж ирсэн. Хуулийн төсөлд.

→ Зах зээлийн үнийн түвшинээс хамааралтайгаар өсөн нэмэгдэх АМНАТ-ын хувь хэмжээг бас оруулж ирсэн.

→ Гуравдугаарт, хэрвээ одоо энэ стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг АМНАТ-аар орлуулах асуудал яригдвал энэ тусгай АМНАТ-ын

бас хувь хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоохоор энэ хуулийн төслүүд оруулж ирсэн байгаа.

Гишүүний асуулт яг энэ тусгай АМНАТ-тай холбоотой. Өөрөөр хэлбэл Цөмийн энергийн тухай хуулиараа 5.5.2, 3 дугаар заалтаар төрийн эзэмшлийн хувь хэмжээ тогтоосон байгаа.

Хэрвээ улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон төр 51-ээс доошгүй хувийг эзэмших ёстой үнэ төлбөргүй. Улсын төсвийн хөрөнгө оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон бол төр тухайн компанийн хувьцааны 34-өөс доошгүй хувийг эзэмшинэ гэдэг ийм зохицуулалт байгаа боловчиг энэ хувьцааны хэрвээ ашигтай, эдийн засгийн үр өгөөжтэй гэж үзэх юм үүнийг ашигт малтмалын тусгай АМНАТ-аар орлуулах зохицуулалт маань энэ хуульд өөрөө байхгүй байсан.

Тэгэхээр бид Ашигт малтмалын тухай хуультай яг нийцүүлээд яг үүний араас хэрэв төр энэ эдийн засгийн үр ашигтай хувилбаруудыг тооцож үзээд 34 хувийг эзэмшихээсээ илүүтэй энэ АМНАТ-аар орлуулах нь эдийн засгийн үр ашигтай гэж үзэх юм бол орлуулах энэ эрх зүйн үндсийг нь нэмж зохицуулж өгсөн байгаа.

Одоо үйлчилж байгаа хуулийн 5.4 дүгээр зохицуулалт дээр зөвхөн энэ 34 буюу 51 хувь дээр хэрвээ төр хөрөнгө оруулалтаа нэмэх тохиолдолд үүнээс дээш хувиар хувьцаа эзэмшиж болно гэдэг ийм зохицуулалтыг бид өөрчлөн найруулсан байгаа.

Өөрчлөн найруулахдаа бид энэ 34 буюу 51 гэдэг энэ 2 хувиас тодорхой хувилбаруудыг бид тооцож үзээд үр ашиг нь тогтоогдох юм бол энэ хувилбарыг

ашиглаж байгаад бид хөрөнгө оруулагчтайгаа энэ хувь хэмжээг тохирч болох юм гэдэг энэ боломжийг нээж өгсөн зохицуулалт орсон.

Үүн дээр ямар аргууд байгаа вэ гэхээр ашигт малтмалын тусгай төлбөрөөр орлуулах асуудал байна. Бүтээгдэхүүн хуваах гэдэг энэ арга байна. Төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх буюу энэ “энгийн хувьцаа”-г “давуу эрхийн хувьцаа”-нд хөрвүүлэх асуудал бас орж ирж байна.

Төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг бас харгалзаж байгаад энэ 34-өөс дээшээ бас ахиулах 50, 51-ээс дээшээ ахиулах боломжийг нь оруулж өгч байгаа юм.

Тэгэхээр бүхэлдээ энэ аргуудыг хэрэглэснээр Үндсэн хуулийн 2019 онд оруулсан энэ нэмэлт, өөрчлөлт болох стратегийн ач холбогдолтой ордын үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдоно гэдэг энэ “50 дээр нэмэх нь 1” гэдэг энэ суурь зарчмыг хангуулах үүднээс энэ хувилбаруудыг бас дурдаж боломжийг нь нээж өгсөн байгаа юм.

Ц.Даваасүрэн: П.Мөнхтулга гишүүн асуултаа асууя.

П.Мөнхтулга: Яах вэ, бүх арга хэлбэрүүдийг л нээлттэй орхичихсон юм шиг байна л даа. Хууль дээр.

Тэгэхдээ бид өөрсдийн хөрөнгийг газар доорх баялгаа үнэлээд, зээлээр аваад, ингээд олон жилийн дараа нөгөө хөрөнгө оруулалтыг хамтран төлөөд явахаар зардлын аргаар ашгаа бууруулаад байдаг.

Тэгэхээр үүнийг хэдүүлээ нэг ойрын хэдэн жилдээ бараг тэвччихвэл

яасан юм. Энэ тохиолдлоор маш олон төслүүд ашиггүй болж байгаа нь үнэн шүү дээ.

Тэгэхээр дараагийн асуух гээд байгаа асуулт дээр сая Ж.Батжаргал гишүүн их чухал асуулт асуулаа.

Франц үүнийг маш олон жил ярьж ярьчихаад одоо гэнэт яаралтай горимоор оруулж ирж байгаа нь үнэхээр Европын Холбоо, энэ Оросын дайнаас болж эрчим хүчний хомсдолд орж байгаа.

Тэгээд энэ яаран тулгамдчихсан байгаа асуудал дээр нь бид бас яг ингэж аясаар нь дагаж гүйгээд байх нь зөв үү? Эсвэл мэдээжийн хэрэг бага оврын цөмийн станцыг энэ тулгамдчихсан байгаа үе дээр нь гэрээн дээрээ нэмж оруулбал яасан юм бэ?

Энэ бас зөвхөн нэг ойрын хугацааны асуудал биш шүү дээ. 10 жилийн дараах асуудал. Оюу Толгойг бид олон жил л ухуулж байгаа. Тухайн үед гэрээн дээрээ тэдэн жилийн дараа нэг тиймэрхүү юм гээд яг тодорхой нэг юм заагаад өгчихсөн бол бас нэхэх юмтай л байсан байх.

Тэгэхээр энэ дээр яг нэг тодорхой, нөгөө тэвдэж явахад нь тэвнээр тусалж байгаа үед бид нарт урт хугацаандаа ямар өгөөжтэй байх вэ гэдгээ тусгавал яасан юм бэ гэсэн ийм саналтай байгаа юм.

Тэгээд энэ дээр манай ажлын хэсэг болон Засгийн газрынхан ямар бодолтой яваа юм бэ? Ерөнхийдөө цаана чинь гэрээнийх нь төслийг би сонсоод мэдээд байгаа л даа. Гэрээ нь бэлэн болчихсон шахуу л юм билээ.

Тэгээд одоо оруулж ирж байгаа нь гэрээндээ тааруулсан хууль яаралтай

горимоор л оруулж ирээд байгаа юм билээ. Яг тэр гэрээн дээр чинь тусчихсан юм байгаа юм уу? Яг тодорхой ийм тийм юм 10 жилийн дараа, 20 жилийн дараа Монголд ийм юм үлдэнэ гээд.

Тэгээд Ж.Батжаргал гишүүн бид хоёрын тэр сүүлийн асуултад тодорхой хариулж өгөөч.

Ц.Даваасүрэн: 5 номерын микрофон. Аер ажлын хэсгээс хариулахаар хүн байвал над руу хэлчхээрэй. Би тэгээд микрофоныг нь заая. Хариулья.

Д.Цолмон: Гишүүний асуултад хариулья.

Цаг хугацааны хувьд яах вэ, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах...

Ц.Даваасүрэн: Нэрээ хэлж хариулахгүй бол протокол явж байгаа шүү.

Д.Цолмон: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Д.Цолмон.

Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах энэ хэлэлцээний ажлын хэсэг олон жилийн өмнө байгуулагдаад, ингээд Засгийн газрын үе үе дамжаад ажлын хэсгийн бүрэлдэхүүнүүд хэлэлцээ хийгдээд явж байсан.

Тэгэхээр одоо юу гэдэг юм гэнэтхэн энэ цаг мөчид яаралтай горимоор хэлэлцэх асуудал огтхон яригдаагүй. Энэ ажлын хэсэг ажиллаад явж байсан.

Өмнөх жилд 2023 оны 10 сард яг жилийн өмнөх хугацаанд Францын талтай хөрөнгө оруулалтын гэрээний

хэлэлцээ хийх ажлын хэсэг урьдчилсан протоколоо зурсан байгаа.

Энэ протокол дээр үндэслэж энэ хуулийн төсөл маань ерөнхийдөө талуудын тохиролцсон нөхцөлүүдийг эрх зүйн орчныг нь бүрдүүлэх үүднээс тусгаад Их Хурлаар хэлэлцүүлж байна.

Энэ хуулийн хүрээнд буюу одоо энэ тохирчихсон асуудал маань хүчин төгөлдөр үйлчилж байж дараагийн хөрөнгө оруулалтын гэрээнийхээ бид хэлэлцээг үргэлжлүүлэх ийм боломжтой болох үүднээс одоо энэ яаралтай горимоор орж ирж байгаа юм гэж ойлгож болно.

Хөрөнгө оруулалтын гэрээн дээр энэ атомын цахилгаан станц барих асуудал тусгах эсэхээ асуудал нээлттэй.

Энэ дээр цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглахтай холбоотой талуудын хоорондын хөрөнгө оруулалтын л асуудал байгаа. Хөрөнгө оруулалтын гэрээний гол онцлог хөрөнгө оруулагчыг үйл ажиллагаа явуулах, орчныг нь тогтвортой байлгах л гол зорилготой.

Тэгэхээр талуудын хооронд тэр үйл ажиллагаа явуулах нь цацраг идэвхт ашигт малтмалын ашиглахтай холбоотой л үндсэн үйл ажиллагаа.

Үүнтэй холбоотойгоор ирээдүйд Монгол Улсын бодлогыг дэмжлэг үзүүлэх чиглэлд хоёр тал хамтран ажиллах чиглэлдээ тодорхой үүрэг амлалтыг авч болно. Үүнийг хоёр талын хэлэлцээний явцад ярилцаад шийдэх боломжтой гэж үзэж байна.

Ц.Даваасүрэн: Нэмэлт байгаа юм уу? Тэр гараа өргөөд байгаа улсууд. 2

номерын микрофон дээр. Ээлжлээд хариулчих. 2 номерын микрофоныг өгье.

Д.Далайжаргал: Цаг хугацааны хувьд ийм юм. Өнгөрсөн оны 10 сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн Францад хийсэн төрийн айлчлалын үеэр санхүүгийнхээ ерөнхий зарчмыг тохиролцчихсон. Энэ бол хамгийн чухал юм. Францын талтай санхүүгээр тохиролцоод Х.Нямбаатар сайд анхны ажлын хэсгийн дарга нь, дараа нь Д.Амарбаясгалан дарга байсан.

Ингээд тохиролцоод явчихсан зүйл. Энэ санхүүгийн бараг гэрээний 40 хувь. Маш чухал зүйл.

Хоёрдугаарт, энэ цаг хугацааны хувьд яаралтай горим гэдэг нь энд Украйны дайн нөлөөлсөн юм огт тийм юм байхгүй. Энэ юу нөлөөлөөд байна гэхээр одоо бид ингээд хөрөнгө оруулалтын гэрээгээ ирэх онд багтаагаад байгуулчихвал жилд 2500 тонн уран олборлох үйлдвэр гэдэг нь өөрөө дэд бүтэц барилгын ажлаа хийхэд 4 жил зарцуулагдах юм.

Тэгэхээр энэ өөрөө тодорхой цаг хугацаатай. Тэгээд 2028 оноос эхлээд жинхэнэ үндсэн үйлдвэрлэл рүү орох учраас энэ өөрөө нэмэлт зүйл.

Бага оврын атомын цахилгаан станц гэдэг нь энэ бол нээлттэй. Үүнийг манайх гаднын орнууд санал болгож байгаа. Гэхдээ үүнийг одоо ярих мэдээж Улсын Их Хурал, Засгийн газар шийдэх байх.

Хоёрдугаарт, Ж.Батжаргал гишүүний асуултад ордын онцлог гэсэн. Энэ өөрөө газар доор уусган олборлох технологи. Өөрөөр хэлбэл байгальд хамгийн эко.

Хоёрдугаарт, эдийн засгийн хувьд маш үр өгөөжөө өгөх юм. Зөвлөлт Холбоот Улс Дорнодод уран олборлож байсан. Тэр бол далд уурхай байсан. Яг нүүрс, алт ухаж байгаа юм шиг тийм байсан. Энэ бол өөр. Ордын онцлог тэрэндээ байгаа.

Ц.Даваасүрэн: 1 номерын микрофоныг өгчихье. 1 номерын.

Э.Нямдаваа: Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа.

Монгол Улсад цөмийн эрчим хүчийг ашиглах асуудлаар тодорхой хэмжээний судалгаанууд хийгдэж байгаа.

Ер нь бага чадлын буюу 300 мегаватт хүртэлх цөмийн эрчим хүчний станц тохиромжтой юм гэсэн урьдчилсан байдлаар ажлын хэсгийн дүгнэлтүүд гарсан байдаг.

Цөмийн эрчим хүч барих асуудал дээр ер нь 3 үе шаттай асуудал байгаа.

Эхний үе шат суурь судалгааны ажлыг хийх ийм шат байгаа. Үүнд дэд бүтцийн 19 чиглэл.

Тухайлах юм бол

- ▶ үндэсний байр суурь,
- ▶ цацрагийн хамгаалалт,
- ▶ цөмийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал,
- ▶ цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх,
- ▶ хаягдлын менежмент, байгаль орчныг хамгаалах гэх мэт

19 дэд бүтцийн чиглэлээр судалгааны ажлыг хийж, үндэсний тийм иж бүрэн тайланг боловсруулах шаардлагатай байдаг.

Тэгээд энэ тайлан дээрээсээ үндэслээд 2 дахь үе шат дээр бид энэ дутуу байгаа зүйлүүдээ гүйцээж хийх асуудлууд яригдана.

Тэгээд Цөмийн энергийн тухай хууль дээр тухайн үедээ яг энэ эрх зүй зохицуулалтуудыг бий болгох боломжтой гэж үзэж байна.

Ц.Даваасүрэн: Гишүүдийн асуултад тодорхой хариулъя. 2 номерын микрофон.

Тэр “байгаль орчинд хоргүй” гээд зүгээр л ерөнхий хэлчхээд байна шүү дээ.

Одоо энэ чинь ингээд хүхрийн хүчил гүн рүү шахчхаад гаргаж ирээд буцаагаад хүхрийн хүчлээ хийнэ гээд байгаа шүү. дээ. Газар луугаа. Энэ чинь протокол явж байгаа.

Тийм учраас буцаад хүхрийн хүчил хийнэ. Тэнд байгаа гүний ус чинь бас урсдаг байх.

Тэгээд үүнд ямар нэг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байгаа юм байна. Тийм ээ. Тэрийгээ тодорхой тайлбарлачих.

Э.Нямдаваа: Газар доор уусгах олборлолт технологи гэдэг нь уран өөрөө 140-өөс 170 метрт шаварлаг орчинд байгаа. Ус байна гэсэн ойлголт байхгүй. Нойтон орчинд байгаа. Тэр нь яаж гаргаж байгаа вэ гэхээр 99 хувь нь ус, 1 хувь нь хүхрийн хүчил гэсэн ийм харьцаатай хүхрийн хүчилтэй усаар доошоо устай орчин бий болгохоор тэр элсэндээ наалдсан уран нь тэр усандаа шингэж байгаа. Тэгэхээр нь гаргаж авна. Тэгээд цикл болгоод буцаагаад хийдэг.

Тэгэхээр эндээс хоёр юм байгаа. Говийн доор их хэмжээний ус байна гэсэн ойлголт байхгүй.

Хоёрдугаарт, нэг хэрэглэсэн 99 хувийн ус, 1 хувийн проценттой хүхрийн хүчилтэй нэг усаа буцааж ашигладаг ийм л технологи байгаа.

Ц.Даваасүрэн: Б.Түвшин гишүүн асуултаа асууж.

Б.Түвшин: Одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа Хөрөнгө оруулалтын болон татварын хууль дээр татварын хувь хэмжээг тогтворжуулах зохицуулалт байж байгаа.

Тэгэхээр нэмэлтээр яагаад тэр элэгдэл тооцох хугацаа болон алдагдал шилжүүлэх хугацааг тооцё гэж оруулж ирсэн юм? Энэ одоо ямар үндэслэлээр энэ тогтворжуулах хүрээг ингэж нэмж байгаа вэ гэдэг нэгдүгээр асуулт байна.

Хоёрдугаар асуулт нь, АМНАТ буюу тэр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг Цөмийн энергийн хуульд тусад нь зааж оруулж ирж байх шиг байна.

Тэгэхээр цаашдаа ер нь тус тусынх нь хууль дээр нь ашигт малтмалын төрөл бүрийнх нь хууль дээр нь АМНАТ-ын тухай хууль ингэж заах юм уу? АМНАТ-ыг ер нь нэгээр нь энэ татварынх нь хууль дээр нь Ашигт малтмалын нөөцийн тухай хууль дээр нь заагаад, бусад салбар хуулиуд дээр нь задалж оруулдаг байдлаар байхгүй бол энэ чинь цаашаагаа хууль болгон дээр заах гээд байгаа юм шиг л ингэж харагдаад байна.

Гуравдугаарт, Оюу Толгой компанитай байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээгээр давхар татварын

гэрээний хувь хэмжээг тогтворжуулсан, тогтворжуулаагүй гээд нэг маргаан одоо болтол яваад байгаа.

Тэгэхээр одоо энэ хоёр улсын хооронд байгуулсан давхар татварын гэрээг хүчингүй болгоход тэр гэрээ одоо тогтворжуулсанд орох уу, орохгүй юу?

Ер нь одоо байгаа давхар татварын гэрээнүүдийг яг энэ хуульд юу гэж оруулах юм? Одоо байгаагаар нь оруулах юм уу? Дараа нь энэ гэрээ дууссаных нь дараагаар тогтворжуулах юм уу? Тогтворжуулах юм уу, тогтворжуулахгүй юм уу гэдэг нэг асуулт байна.

Дөрөв дэх нь, энэ олон улсад энэ “Давхар татвараас зайлсхийх олон талт конвенц” гэж байгаа. Манай улс энд нэгдээд ороод явж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгэхээр энэ конвенцод нэгдэж орсон татварын зүйл ангиудыг тогтворжуулахгүй биз дээ? Ерөөсөө энэ конвенцын гол асуудал нь нь хөгжиж байгаа болон ядуу улсууд татварынхаа.

Тэгэхээр ерөөсөө энэ олон талт конвенц хөгжиж байгаа болон ядуу жижиг улсууд, гадаадын өндөр хөгжилтэй ялангуяа томоохон хөрөнгө оруулалтаас олон төрлийн орлогоор татвараа алдаад байна гэдэг дээр зөвлөмж өгдөг байгууллага гэж би ойлгож байгаа.

Манайх энд элсээд орчихсон. Элсээд орчихсон энэ конвенцоор зөвлөж байгаа тэр зөвлөмжүүдийг тогтворжуулахгүй биз дээ. Өөрөөр хэлбэл, энэ гэрээгээр бид урьдчилаад үүнийг нь тогтворжуулчих юм бол одоо бид одоо нөгөө олон талт гэрээ конвенцоос гадуурх зүйл буюу тогтворжуулахгүй байх зөвлөж

байгаагийнх нь эсрэг явчих гээд байгаа юм биш үү гэсэн нэг ийм санаа. Үүнийг нэг асуучихъя.

Тавдугаарт, хууль дээр нь 34 хүртэлх хувийг бид үнэ төлбөргүйгээр эзэмшиж болно гэхихсэн байгаад байдаг. Бид одоо оруулж ирэхдээ дүйцүүлнэ гээд.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 1 минут нэмэлтээр Б.Түвшин гишүүнд өгье.

Б.Түвшин: Дүйцүүлнэ гэдэг чинь ямар нэгэн одоо бид өр төлбөрийг суутгуулна гэсэн үг үү? Ямар нэгэн юмаар хаана гэсэн үг үү?

Ер нь ирээдүйд орох АМНАТ-аасаа суутган тооцож байж тэр тодорхой хувийг эзэмшинэ гэсэн үг үү? Яагаад “үнэ төлбөргүй эзэмшинэ” гээд хуульд заачихсан юмыг “дүйцүүлнэ” гэж оруулж ирээд байгаа юм бэ?

Сүүлийн асуулт энгийн хувьцааг давуу эрхтэй болгох тухай яриад байгаа. Давуу эрхтэй хувьцаа энгийн хувьцаа хоёр чинь хууль дээр заасан тус тусын эрх, үүрэг, хариуцлагатай.

Тэгэхээр давуу эрхтэй хувьцаа руу шилжүүлчихвэл энгийн хувьцааны эрх үүргээ бүрэн эдэлж чадах уу? Тэр дээр бүрэн эдэлнэ гэсэн тийм баталгаа байгаа юу? Энэ хэдэн асуултыг асууя.

Ц.Даваасүрэн: Асуултад хариулъя. 4 Номерын микрофон Н.Учрал сайд.

Н.Учрал: Б.Түвшин гишүүний асуултад хариулъя.

Энэ яг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Ашигт малтмалын

хуулиар хэлэлцээ хийгээд явах гэхээр бас бэрхшээлүүдтэй тулгараад байсан юм билээ. Өмнөх ажлын хэсгүүд.

Тэгээд Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр протоколд тэр зарчмын саналуудаа тохирсон. Энэ Монголд ашигтай ийм хэлэлцээ өнгөрсөн хугацаанд хийгдсэн юм байна.

Яагаад гэхээр анх удаа АМНАТ буюу 5 хувийн суурь АМНАТ байгаагаа тусгай АМНАТ 5 байгаа.

Тэгээд өсөн нэмэгдэх АМНАТ гээд. Хамгийн дээд талдаа 19 хувийн АМНАТ авч болох ийм боломжийг хэлэлцээний үеэр тохиролцсон.

Тэгээд эргээд энд хэлэлцээрээ үргэлжлүүлэе гэхээр, хуулийн хүрээнд хийх гэхээр асуудал үүсээд байсан юм байна.

Яагаад гэхээр өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар нөгөө тусгай АМНАТ нь 5-аас дээш гарч болдоггүй. Нөгөө тал нь болохоор АМНАТ-аа өсгөөд ингээд тохирч болно гээд байтал манай хуулиа харахаар 5-аас дээш гарахгүй гээд заачихсан.

Тэгэхээр үүнийг нь тийм хатуу хуульчлах гэхээсээ илүүтэйгээр дээшээ хэд ч байж болохоор хэрвээ хуулийн хүрээнд нээгээд өгвөл цаашдаа энэ төрлийн гэрээ хэлцэл хийхэд ингээд харилцан тохиролцоод хийх бололцоог бүрдүүлсэн.

Сая Б.Түвшин гишүүний асууж байгаа асуулт буюу энэ Үндэсний баялгийн сангийн хууль дээр яг өнгөрсөн парламент дээр бид нөгөө улсын төсвөөс нөөцийг нь тодорхойлсон бол “50 хүртэлх” хувийг нь үнэ төлбөргүйгээр

эзэмших. “Хүртэлх” гэж байгаа. Хэрвээ өөрсдөө санхүүжилт гаргаад нөөцийг нь тодорхойлсон бол “34 хүртэлх” хувийг нь үнэ төлбөргүйгээр эзэмших гэсэн ийм хоёр заалт байсан.

Энэ заалт Ашигт малтмалын хуулиар болохоор төрийн эзэмшлийн хувийг одоо нөгөө АМНАТ-аар орлуулах, эсвэл бүтээгдэхүүн хуваахаар орлуулахыг нь нөгөө хуулиараа нээлттэй байдаг.

Гэтэл Цөмийн энергийн хууль дээр болохоор нөгөө төрийн эзэмшлийн хувь хэмжээг АМНАТ-аар орлуулах ийм эрх зүйн орчин байхгүй.

Тийм учраас Цөмийн энергийн хуулийг л өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Ашигт малтмалын хуультайгаа л яг ижилхэн л болгож байна гэсэн үг.

Тэгэхээр нөгөө төрийн эзэмшлийн 34 байна уу, 50 хүртэлх байна уу үүнийг заавал одоо нөгөө Оюу Толгойн гэрээтэй адилхан ногдол ашиг хүлээгээд суудаг биш АМНАТ-аа өсгөж болж байна, эсвэл бүтээгдэхүүн хуваахаар болж байна. Энэ бол нөгөө гэрээ хэлцлийн үед өөр өөрсдөө хоёр тал шийдвэрлээд явах бололцоог нь нээгээд өгье гэдэг зорилгоор оруулсан.

Түүнээс биш нөгөө дүйцүүлнэ гэдэг ойлголт байхгүй. Зүгээр АМНАТ-аар юм уу, бүтээгдэхүүн хуваахаар ч юм уу орлуулж болно гэдэг Ашигт малтмалын хуулийн заалтыг л Цөмийн энергийн хуульд хийж байгаа гэсэн үг.

Тэгэхээр одоо яах вэ, энэ хууль батлагдсанаараа хөрөнгө оруулалтын энэ гэрээндээ ч биш цаашдаа ер нь Цөмийн энергийн хуулиа бариад одоо энэ урантай холбоотой янз бүрийн гэрээ хийгдэх,

хөрөнгө оруулалт татах орчинд бид ямар боломжтой болж байна вэ гэхээр ерөөсөө тусгай АМНАТ-аа хэдээр тохирох вэ гэдгийг Засгийн газар өргөн мэдүүлснээр Их Хурал шийддэг.

Дээрээс нь өсөн нэмэгдэх АМНАТ гэдэг ойлголт бий болчихсон буюу тухайн бүтээгдэхүүний үнэ зах зээл дээр өсөх тусам өсөн нэмэгдэх АМНАТ нь өсдөг.

Яг өнөөдрийнхөөр бодвол жишээ нь Оюу Толгой дээр бид суурь АМНАТ гээд л **5 хувь** л авч байгаа. Одоогийн яг энэ хэлцлээр “тусгай”, “суурь”, “өсөн нэмэгдэх” гэвэл яг өнөөдрийн ураны нэг фунтийн үнэтэй нь харьцуулаад үзэх юм бол яг одоо энэ хуулийн төслийн хүрээнд **15 хувийн АМНАТ авна** гэсэн үг.

Тэгэхээр тухайн байгууллага ашигтай байна уу, ашиггүй байна уу, эсвэл менежментэд нь төр заавал оролцох шаардлагагүйгээр шууд хамгийн багадаа 15 авна. Хамгийн дээд талдаа 19 авна. 10 хувийн ногдол ашиг гэдэг нь энгийн хувьцааг давуу эрх болгож байгаа нь тэргүүн ээлжид ашиг орлогыг хуваарилах энэ зарчим давуу эрхийн хувьцаа дээр байгаа.

Дээрээс нь санхүүгийн хариуцлага бид хүлээхгүй гэдэг ийм л зарчмыг тусгах гээд.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 6 номерын микрофон. Тэр санхүүгийн холбогдолтой юманд нь хариулъя.

Б.Тэлмүүн: Сангийн яам Б.Тэлмүүн. Б.Түвшин гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээр асуултын хувьд яг бид одоо Цөмийн энергийн хуулиараа

хөрөнгө оруулалтын гэрээ хийгээд энэ татвартай холбоотой асуудлыг зохицуулах гэхээр Цөмийн энергийн хууль, Татварын ерөнхий хууль, Хөрөнгө оруулалтын хууль хооронд ийм зөрүү гараад байгаа.

Яаж байна гэхээр Татварын ерөнхий хуулиар хөрөнгө оруулалтын төсөл 4.1.1-д хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн төлөх татварын хэмжээг Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны дагуу гээд. Цөмийн энергийн хууль байхгүй болчихоод байгаа.

Тэгэхээр бид энэ 3 хуулийг нийцлийг нь хангуулж жигдрүүлэх нэг шаардлага гараад байдаг.

Хоёр дахь асуудал нь, Хөрөнгө оруулалтын хуулиар татварын орчныг тогтворжуулна гээд байдаг. Хуулийн 3.1.7 дээр татварын орчин гэдэг нь хуульд заасан татварын төрөл, тэдгээрийн хэмжээг тодорхойлох, ногдуулах төлөх эрх зүйн зохицуулалтын бүрдлийг гээд маш өргөн хүрээтэй.

Тэгэхээр бид Оюу Толгой болон өмнөх хугацаанд гарсан энэ татвартай холбоотой гол сургамж бид яг татварынхаа юуг тогтворжуулах вэ гэдэг хүрээ хязгаарыг маш тодорхой заахгүйгээс одоо бараг ингээд нөгөө дүрэм журмууд, таны хэлж байгаа татвараас зайлсхийхийн эсрэг стандартууд хүртэл ингээд тогтворжих, тогтворжихгүйн тухай ойлголт гараад байгаа.

Тэгэхээр бид яах вэ, олон улсын туршлагаудыг нэлээн судалж үзсэн. Олон улсын туршлага бол аль болох тогтворжуулахгүй байх гэдэг нэгдүгээр зөвлөмж байдаг.

Хоёрдугаарт нь, зөвхөн яг одоо тэр санхүүгийн модельтой холбоотой гардаг параметруудийг тогтворжуулах нь зүйтэй гээд.

Тэгээд бид зөвхөн санхүүгийн модель, энэ үр ашгийн тооцоон дээр

- шууд нөлөө үзүүлдэг хувь хэмжээ,
- алдагдал шилжүүлэх хугацаа,
- элэгдэл байгуулах хугацаа

гэсэн энэ 3-ыг л ойлгоно. Өөр ямар нэгэн дүрэм журам болон одоо тэр бусад асуудал тогтворжилт орохгүй гэдгийг тодорхой заагаад хууль эрх зүйн орчноор тодорхой болгож байгаа.

Хоёрдугаар асуудлын хувьд давхар татварын гэрээтэй холбоотой Оюу Толгойн маргаан одоо явж байгаа.

Нэг талдаа олон улсын гэрээ дотоодын хуулийг давна. Энэ хоёр улсын хооронд хүлээсэн үүрэг байдаг. Энэ агуулгаар Оюу Толгойтой холбоотой арбитрын маргаан үргэлжилж байгаа.

Ц.Даваасүрэн: 1 минут нэмээд өгчихье. 6 номерт. Гүйцээгээд хариулчих.

Б.Тэлмүүн: Бидний хувьд Франц болон бусад улстай байгуулсан давхар төрийн гэрээг тогтворжуулахгүй гэдэг ийм байр суурь хатуу илэрхийлж байгаа.

Тэгэхээр үүнийг хэлэлцээрийн явцдаа бид тусгаад явна.

Дараагийн асуудалдаа энэ **BEPS** [Татварын суурийг багасгах болон ашиг шилжүүлэхийн эсрэг]-тэй холбоотой асуудлыг бид энэ дээр маш хатуу байр сууриа илэрхийлээд протоколын 1.1-ийн “б” дээр яг таны хэлж байгаа агуулгаар оруулсан байгаа.

Юу гэж байна гэхээр “Монгол Улс нь татварын суурийг багасгах ашиг шилжүүлэхийн эсрэг байгууллагын гишүүн орон болохын хувьд хөрөнгө оруулалтын гэрээнд татварын суурийг багасгах энэ BEPS-ийн эсрэг дүрэм болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын зарчимд нийцсэн байх явдлыг хангах” гэдгээр одоо ямар ч байсан тохирчихсон явж байгаа.

Тэгэхээр энэ дээр ямар нэгэн байдлаар татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх, татвараас зайлсхийхийн эсрэг энэ дүрэм журам, олон улсын стандартууд, үнэ шилжилтийн стандартыг ямар нэгэн байдлаар бид тогтворжуулахгүй гэдэг энэ хатуу байр сууриа хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээр дээр хатуу баримтлаад явна.

Ц.Даваасүрэн: 1 минут.
Тодруулъя. Б.Түвшин гишүүн.

Б.Түвшин: Эхний асуулт татварын хувь хэмжээнээс гадна тэр элэгдэл тооцох хугацаа болон алдагдал ирээдүйд шилжүүлэн тооцох хугацаа гээд ингээд өргөтгөж байна.

Энэ өргөтгөж байгаа яг үндэслэл нь яг юу юм? Одоо бид өмнөх алдаа онооноос гэж сая та хариулж л байх шиг байна.

Яг одоо энэ хэлцэл болон ирээдүйд болох энэ олон хөрөнгө оруулалтын хэлцлүүд дээр үүнээс илүү нэмэлт, өөрчлөлтүүд ороод байхгүй ннэ 3-аар тогтворжуулахад болох юм гэсэн тэр үндэслэлийг нь нэгдүгээрт сонсчихмоор байна.

Хоёрдугаарт, элэгдэлд тооцох хугацааг бид одоо ямар нэгэн байдлаар

тохирчихсон байлаа гэхэд яах вэ тэр хугацаа цаашаа татварт ээлгүй хүндрэхээр тохиолдолд тогтворжуулчихна.

Наашаа эерэг болж байгаа тохиолдолд яаж тооцох вэ, яаж гэрээн дээр өөрчлөлт орох вэ гэдэг нэг ийм асуулт байна.

Тэр энгийн хувьцаа давуу эрхтэй болж авах гэж байгаа. Тэгээд давуу эрхтэй болонгуутаа бид тэр хувьцаанд ногдол ашгаа ямар нэгэн байдлаар бүтээгдэхүүн хуваах ч юм уу, АМНАТ-аа өсгөх.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Хариулъя. 6 номер.

Б.Тэлмүүн: Сангийн яам
Б.Тэлмүүн Б.Түвшин гишүүний асуултад нэмж хариулъя.

Бид илүү хумьж байгаа юм.

Нэгдүгээрт, одоо хүртэл ингээд явж байгаа Оюу Толгойн гэрээн дээр жишээ нь 15.23.1 дээр татварын орчин гэдэгтээ юу оруулж байна гэхээр “татвартай холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын гэрээ, эрх зүйн бусад баримт бичгийг гэрээ байгуулсан өдөр хүчин төгөлдөр байсан хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын гэрээ, эрх зүйн бусад баримт бичгийг ойлгоно.” гээд ингээд маш ерөнхий хүрээтэй.

Энэ дээр бараг ингээд тайлангийн маягт хүртэл орох хэмжээний.

Одоогийн Хөрөнгө оруулалтын хууль дээр мөн адил.

Би түрүүн бас уншиж өгсөн. 3.1.7 дээр татварын төрөл, тэдгээрийн хэмжээг тодорхойлох, ногдуулах, төлөх эрх зүйн орчны бүрдлийг гэж байгаа.

Тэгээд өөрөөр хэлэх юм энэ ингээд татвартай холбоотой бүх процесс, ажиллагаа, хувь, хувь хэмжээ болон бүх дүрэм журмууд иж бүрдлээрээ тогтворжихоор заасан байгааг бид зөвхөн энэ 3 параметрыг.

Яагаад энэ 3-ыг оруулж байгаа вэ гэхээр энэ 3 нь өөрөө нөгөө яг санхүүгийн модель, ТЭЗҮ дээр шууд үр өгөөжийн тооцоонд нөлөө үзүүлдэг. Элэгдэл тооцох хугацаа болон алданги шилжүүлэх.

Ц.Даваасүрэн: Би нэг зүйл асууя.

Уран бол ер нь ирээдүйд нэлээн чухал эрчим хүчний эх үүсвэр болох байх гэж би ингэж бодож байгаа юм. Тийм технологиуд явж байна.

Тэгэхдээ энэ төсөл харьцангуй жижиг төсөл л дөө. Оюу Толгойг бодоход.

Энэ чинь төслийн нийт хугацаанд 8 тэрбум доллар гэж байгаа. Тийм ээ. Гэтэл 8 тэрбум долларыг манай “Эрдэнэс Тавантолгой” нэг жилийн дотор л оруулж байгаа шүү дээ.

Тэгэхдээ энэ дээр би зүгээр нэг зүйлийг жоохон анхаараач ээ гэж бодоод байгаа юм.

Ашигт малтмалын нөөц ашигласны 5-хан хувь. Гэтэл энэ орж ирж байгаа хуулиуд дотор мөн алдагдал, элэгдлийг ирээдүйд тооцъё гээд яг Оюу Толгойн загвар явж байгаа байхгүй юу.

Тэгэхээр эндээс юу харагдаад байна вэ гэвэл нөгөө зардлаа өсгөдөг хувилбар чинь явах нь гэж харагдаад байгаа байхгүй юу. Тэгээд та нар манай талын эзэмших хувийг бүр 10 болгочихъё гээд байх шиг байгаа юм.

Тэгэхээр өшөө л нөгөө зардлаа хянаж чадахгүй болно.

Ерөөсөө одоо энэ Оюу Толгой дээрээ алуулж байгаа юм чинь тэр шүү дээ. Зардлаа бид хянаж чаддаггүй. Тэгээд нөгөөдөх нь зээл аваад л зардлаа өсгөөд л. Ингээд л манайд ямар ч ногдол ашиг ноогддоггүй.

Оюу Толгой өөрөө **44 сая тонн зэс**. Энэ чинь 400 тэрбум доллар байхгүй юу. Зөвхөн **зэс нь 400 тэрбум доллар**.

Алт нь 1800 тонн. Одоо 2600 хүрчихсэн байгаа. Тийм ээ. Алтны үнэ.

Тэгэх юм бол энэ **1800 тонн алт** гэдэг чинь байна шүү дээ **130 тэрбум доллар**.

Нийтдээ Оюу Толгой **530 тэрбум доллар**. Өнөөдрийн зах зээлийн ханшаар.

Гэтэл бид жилд

- ▶ 5-хан хувиар 200-хан сая доллар авч байгаа.
- ▶ 10 жилд 2 тэрбум.
- ▶ 50 жилд хэд вэ. 10-хан.

500 тэрбумаас 10-хан тэрбумыг Монголд татвараа төлж байна шүү дээ. Оюу Толгой.

500 тэрбумаас 10-хан тэрбумыг.

Энд бас 5-хан хувь.

Хэрвээ бид хувиа багасгахаар гоё гэдэг нэг тархи угаалт яваад байгаа байхгүй юу. Зардлаа хянаж чаддаггүй юм гэж.

Үгүй ээ, баялгаад 50 хувь гэж яагаад болдоггүй юм. Үгүй энэ чинь бид баялгаа үнэлж тооцох ёстой шүү дээ. Тэр П.Мөнхтулгын хэлээд байгаа шиг. Яагаад баялгаа үнэлэхгүй байгаа юм.

Та нар үйлдвэрээ гарга. 50 хувь. Манайх баялгаа гаргая. 50 хувь. Яагаад ингэж болдоггүй юм.

Яагаад ингэж үндэснийхээ эрх ашгийг хамгаалж болдоггүй юм. Тэгээд 10 хувийг нь зөвшөөрөөд суугаад байдаг.

Тэгвэл зардлаа хянахгүй. Зардлаа хянахгүй юм бол 5 хувь чинь юу ч биш.

Үүнийг бид одоо бас жаахан анхаарахгүй бол болохгүй нь гэж. Ийм зүйлүүд дээр би та бүгдийг хоёр асуулт байна. Зардлаа яаж хянах гэж байна? Баялгаа яаж үнэлж байна?

Яагаад бид баялгаараа энэ 50 хувиа эзэмшиж болохгүй байгаа юм? Баялаг байхгүй бол энэ үйлдвэр байхгүй шүү дээ.

Энэ хоёр асуултад нэг хариулаадхаач. Баялгаа яаж үнэлэх гэж байна?

Хоёрдугаарт, тэр миний саяын асуусан. 4 номерын микрофон.

Н.Учрал: Тийм. Ц.Даваасүрэн гишүүн их чухал асуудлыг хөндөж байгаа юм.

Үнэхээр одоо бид баялгаа үнэлж байж, тэд хөрөнгө оруулалтаа хийж байж л цаашдаа хөрөнгө оруулалтын гэрээ амилна шүү дээ.

Тэгээд өнгөрсөнд бид алдсан алдаа юу байсан бэ гэхээр ерөөсөө жишээ нь Оюу Толгой дээр бол одоо яг татварын маргаан үүсээд явж байна л даа.

2.8 тэрбум доллар байх. Түүний 5 хувийн АМНАТ-аас олсон хуримтлал чинь **800.0 сая доллар** юм билээ шүү дээ. Нэг ёсондоо бодитой одоо яг хуримтлал өгөөд Монгол Улсад юу нь ашигтай байсан бэ гээд харахаар яг 5 хувийн АМНАТ л үлдсэн байна.

Тэгэхээр бид одоо энэ АМНАТ аваад байгаа чинь юунаас болж байна вэ гэхээр юутай холбоотой вэ гэхээр яг үнэндээ энэ чинь нөгөө борлуулалтын үнэлгээнээс нь авч байгаа байхгүй юу.

Тухайн компанийн ногдол ашиг биш. Энэ чинь борлуулалтын үнэлгээнээс нь тэр АМНАТ-аа авах буюу энэ 5 хувь чинь **сууриараа 5, тусгай нь 5, өсөн нэмэгдэх нь дахиад 5**. Одоо хамгийн багадаа.

Тэгэхээр 15 хувийн АМНАТ авна гэдэг маш өндөр АМНАТ тооцож байгаа бараг анхны жишиг юм билээ.

Тийм учраас үүнийгээ хуулиа хийж байгаад энэ өндөр АМНАТ-ыг ядаж авъя.

Ингэвэл тухайн компани тэр ногдол ашиг байна уу, зардлаа өсгөөд ашгаа хуримтлуулахгүй байх асуудлаас холдоно.

Гэхдээ нөгөө тал юу гэж байна вэ гэхээр нөгөө баялгийг чинь үнэлээд бид хөрөнгө оруулалт хийж байгаа учраас бид та нараас ямар нэгэн санхүүжилтийн үүрэг хариуцлага та нарт ноогдуулахгүй.

Та нар Монголын төр засаг ямар нэгэн санхүүжилт хийхгүй. Огт. Яагаад гэвэл байгалийн баялгаараа одоо үнэлүүлж байгаа учраас.

“Зөөвч овоо” дээр ч гэсэн үнэлгээ хийсэн байсан. Тийм ээ. 673 гээд эхний байдлаар тогтоогоод үнэлгээ хийгээд явж байгаа юм билээ.

Тэгэнгүүтээ түүн дээрээ 10 хувийн ногдол ашгаа юу гэж ярьж байна вэ гэхээр 10 хувь төр оролцож байгаагаа баталгаажуулж байгаа.

Гэхдээ эндээс дахиад эрсдэл үүснэ. Дахиад нөгөө 10 хувь дээрээ бид хариуцлага хүлээх болоод эхэлбэл яах вэ. Ирээдүйд хөрөнгө оруулалт хийгээд 10 хувь дээрээ дахиад янз бүрийн санхүүгийн хариуцлага хүлээгээд тэр 10 хувь дээр чинь импакт өгөөд эхэлбэл яах вэ гэдэг эрсдэл байсан учраас компанийн хуулиараа энгийн хувьцаагаа давуу эрхийн хувьцаа болгоод 10 хувийг манай тал авснаараа ямар ч санхүүгийн хариуцлага хүлээхгүй, дээрээс нь ногдол ашгийн эхний ашгийг тэргүүн ээлжид авна гэдгийг тусгаж өгч байгаа.

Тэгэхээр 10 хувийг авснаараа Монголын төр оролцож байгаа. Гэхдээ эндээсээ тэргүүн ээлжид ногдол ашгаа авна. Тэр ногдол ашиг хаашаа орох вэ гэхээр Баялгийн сангийн хуулиараа хуримтлалын санд орно. Нөгөө эрүүл мэнд, боловсрол, орон сууцад зарцуулагдана.

Үлдсэн дээр нь болохоор тэд ашигтай байна уу, эсвэл зардлаа өсгөөд ашиг гаргахгүй байхаас үл хамаараад нийт борлуулалтаас нь Оюу Толгой дээр 5-ыг авдаг шиг хамгийн багадаа 15-ыг авна. Дээд талдаа 19-ийг авна гээд шийдчихвэл энэ одоо хамгийн эрүүл үзэгдэл болох юм байна гэдэг байдлаар л бид хийх гэж хичээсэн юм.

Тэгээд яах вэ энэ чинь өмнө нь 2 ажлын хэсэг байгуулагдаад тэгээд тэр Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр протокол зурчихсан байсан чинь яг энэ хэлэлцээрийг үргэлжлүүлэх гэсэн чинь хууль дээр дээд тааз нь 5 байна гээд заачихаар бид нэмж чаддаггүй.

Тэгэхээр нь Цөмийн энергийн хууль дээр өөрчлөлт оруулаад хийгээд дээрээс нь тэр энгийн хувьцаагаа давуу эрхийн хувьцаа болгоод санхүүгийн хариуцлагаас холдоод тэгэхдээ төр оролцоогүй биш оролцсон ногдол ашгаа ч авна, АМНАТ-ынхаа орлогоор ч авна. Мэдээж тэр аж ахуйн нэгжийн орлогын албан татвар. Дээрээс нь Үндсэн хуулийн тэр 6.2 байгалийн баялгийн “50 дээр нэмэх 1” буюу дийлэнхийг ард түмэн эзэмшинэ гэдэгтээ л хүргэх гэж л энэ хэлэлцээрийг хийгээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хууль гарснаараа гэрээ ч юм уу, шууд танилцуулагдаад энэ төсөл явах гээд байгаа зүйл биш.

Энэ хууль гарснаар энэ хуульдаа нийцүүлээд гэрээнийхээ нөгөө хэлэлцээрийг үргэлжлүүлээд тэгээд Их Хуралд дахиад мэдүүлнэ.

Мэдээж АМНАТ-ыг хэт хэмжээгээр яаж тогтоохыг Их Хурал шийднэ. Хуулиараа.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр зүгээр зардлаа хянах асуудал тэр хувьцаатай шууд холбоотой. Төлөөлөн удирдах зөвлөлд хэдэн хувь эзэмшиж байна вэ гэж.

Тийм учраас баялаг өөрөө хөрөнгө оруулалт мөн. Үүнийг миний хойч үе мах цусандаа шингэтэл бодоорой. Эх орноо битгий худалдаж байгаарай. Баялаг өөрөө хөрөнгө оруулалт мөн.

Тэд нар тоног төхөөрөмжөөрөө хөрөнгө оруулалт хийнэ. Ингээд хувиа өндөр байлгах хэрэгтэй.

Тэгж байж та нар хянана.

Тэр ирээдүйд үүсэх асуудал гэдгийг компани өөрөө хариуцах ёстой. Хөрөнгө оруулалт хийлээ, үйлдвэр эхлээд тэгээд дуусаа байхгүй юу. Тэрнээс цааших санхүүгийн бүх хариуцлага компани өөрөө үүрдэг жамтай.

Эрдэнэт тэгж байгаа биз дээ. Эрдэнэтээр бид хариуцлага хүлээгээд байх дээр сөнөчих гээд байгаа юм байхгүй л байгаа биз дээ.

Тийм учраас тэр ирээдүйд хариуцлага хүлээнэ гэж айлгаж хувьгүй болгох гэдэг юм бол гаднын тархи угаалт.

Тийм учраас манай баялгаа хөрөнгө оруулалтад тооцоорой гэж. Зардлаа яаж хянах вэ гэдгээ бодоорой. Тэр суурь 50 хувь чинь одоо бас бага байна гэж би ингэж бодоод байгаа юм.

Ингээд гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй

саналын томьёолол гаргах гишүүн байна уу?

Би нэг санал гаргая. Би ингэж үзээд байгаа юм.

Энэ яах вэ Оюу Толгойг бодоход нэг сайн юм орж ирсэн нь өсөн нэмэгдэх роялти тооцож байгаа.

Тэгэхдээ уран өөрөө хөрөнгийн бирж дээр одоо ингээд өрсөлдөөн үүсгээд чөлөөтэй яваад байдаг ийм баялаг биш ээ. Үүнийг боловсруулна, баяжуулна гэдэг 6, 7-хон орны хийдэг технологи.

Тийм учраас өсөн нэмэгдэх роялтигаар нэг их юм авна гэж горьдолтгүй.

Тэгэхээр би одоо суурь нөөцийн төлбөрийг 9 хувь байлгая гэдэг санал хураалгана. Тэгээд та нар өөрсдөө шийдээрэй.

Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт 20 штрих 1 дүгээр зүйлийн 10 штрих 3 дахь хэсгийн үнэлгээний ашигт малтмалын нөөцийн төлбөрийг “5 хувиар” гэснийг “9 хувиар” гэж өөрчлөх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн.

Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар энэ санал дэмжигдлээ.

Баярлалаа. Ж.Баясгалан гишүүн бас дэмжсэн байна. Протоколд тэмдэглэе.

Хэдүүлээ жоохон ард түмэндээ өгөөжөө нэмэгдүүлэхийн төлөө л байх

хэрэгтэй шүү. Эх орныхоо эрх ашгаас ерөөсөө урваж болохгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэн санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

Одоо дээрх хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Татварын хуультай холбогдуулаад. Татварын ерөнхий хуультай холбогдуулаад суучих алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцүүлэн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг

Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хороонд танилцуулах гишүүн байна уу? Ж.Батжаргал гишүүн танилцуулчих уу? Ж.Батжаргал гишүүн танилцуулъя.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа. /алх цохив/

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын даргын захирамжид тусгагдсан асуудлаар “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг бэлтгэн Та бүхэнд тараасан байгаа.

Байнгын хорооны тогтоолын төслөөс асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 92.3 хувиар санал дэмжигдсэн байна.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа.

Байнгын хорооны гишүүдэд баярлалаа.

Хуралдаан 1 цаг 38 минут үргэлжилж, 12 цаг 21 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД